

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2026 оны 05 сарын 01 өдөр

№ R-2026-28

Улаанбаатар хот

Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр батлах тухай

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.11 болон 36.12 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь заалт, Монголбанкны Ерөнхийлөгч болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А-262/262 тоот хамтарсан тушаалаар батлагдсан Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журмын 1 дүгээр зүйлийн 1.2.6 дахь заалт, 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэг, ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.26 дахь хэсгийг тус тус үндэслэн, Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:


- Банкны хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлж жижиг хувьцаа эзэмшигчдэд тулгарч буй хүндрэлийг бууруулах, тухайн хүндрэлийг улам дордуулах нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн R-2025-36 тоот тогтоолоор батлагдсан Банкны хувьцаа эргүүлэн худалдан авах өмнөх хөтөлбөр дуусгавар болсноос хойш үргэлжлүүлэн, 12 сарын хугацаатай хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг батлахыг ТУЗ-д санал болгосныг; мөн
- ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын саналыг хэлэлцээд хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг батлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Монголбанкнаас зөвшөөрөл олгосон тохиолдолд, Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр ("Хөтөлбөр")-ийг Банк өөрийн гаргасан энгийн хувьцааны 7,500,000 (долоон сая таван зуун мянга) ширхэг хүртэлх хувьцааг эргүүлэн худалдан авах эрхтэйгээр, дараах нөхцөлөөр баталсугай:

1	Эргүүлэн худалдан авах хувьцааны тоо	7,500,000 ширхэг хүртэл
2	Эргүүлэн худалдан авах нэгж хувьцааны үнэ	1,200 төгрөг хүртэл
3	Хөтөлбөрт зарцуулах нийт дүн	9,000,000,000 төгрөг хүртэл
4	Хөтөлбөр хэрэгжих хугацаа	12 сар

- Хөтөлбөр хэрэгжих хугацаа нь Монголбанкны зөвшөөрөл олгосны дагуу нийтэд зарласан өдөр эсхүл ТУЗ-ийн R-2025-36 тоот тогтоолоор батлагдсан хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр дуусгавар болсон өдрийн аль сүүлийн өдрөөс эхлэн 12 сарын хугацаанд үргэлжлэх ба нийт эргүүлэн худалдан авах хувьцааг бүхэлд нь худалдан



авсан, эсхүл Хөтөлбөрт зарцуулах нийт дүнг бүрэн зарцуулснаар уг хугацаанаас өмнө дуусгавар болж болохыг дурдсугай.

3. Хөтөлбөрийн дагуу эргүүлэн худалдан авсан хувьцааг халаасалсугай.
4. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хувьцаа эргүүлэн худалдан авах ажлыг гүйцэтгэх, зохицуулагч байгууллагаас зохих зөвшөөрөл авах, харилцах зэрэг энэ ажлыг зохион байгуулахтай холбоотой шаардлагатай, эсхүл зохистой гэж үзсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд даалгаж, холбогдох эрхийг олгосугай.
5. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ





“ХАС БАНК” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Г.ЦЭВЭГЖАВ ТАНАА

МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,
Цахим хуудас: www.mongolbank.mn

2026.07.22 № А-1/648
танай _____-ны № _____-т

Хувьцаа эргүүлэн худалдан авч,
халааслахыг зөвшөөрөх тухай

Танай банкнаас 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 1/4732 тоот албан бичгээр ирүүлсэн олон нийтэд санал болгож гаргасан хувьцааны тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авч, халааслах хүсэлттэй танилцлаа.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.3 дахь заалт, Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.12 дахь хэсгийг үндэслэн “Хас банк” ХК нь хувьцаа эргүүлэн худалдан авч, халаасалсны дараа Монголбанкнаас тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа тул олон нийтэд санал болгож гаргасан 7,500,000.00 (долоон сая таван зуун мянга) ширхэг хүртэл хувьцааг нэгж бүрийг нь 1,200.00 (нэг мянга хоёр зуу) хүртэл төгрөгөөр буюу нийт 9,000,000,000.00 (есөн тэрбум) төгрөг хүртэл эргүүлэн худалдан авахад татгалзах зүйлгүй болно.

Түүнчлэн, энэхүү зөвшөөрлийн дагуу хувьцаа эргүүлэн худалдан авсан бодит худалдан авалтын тайлан болон нөлөөллийг улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор Банкны хяналт шалгалтын газарт тайлагнаж ажиллахыг үүгээр мэдэгдэж байна.

ЕРӨНХИЙЛӨГЧ



С.НАРАНЦОГТ

1526022475

XACBANK JSC

Price-sensitive information

Ad-Hoc announcement /Form 3/	
Reporting period	23 July 2026
Information of issuer	Name: XacBank JSC State registration certificate number: 000239852 Registration number: 2578697 Securities code: MN00XAC05687 Address: XacBank HQ Building, Ulaanbaatar-14200, Post Branch 20A, PO Box-72, Mongolia Phone: 75771888 Email: info@xacbank.mn Website: www.xacbank.mn
Name of registered trading entity	Mongolian Stock Exchange
Classification of business activities	Banking and financial sector
The total number of shares issued by the issuer	1,052,700,000 common shares
The name of the specialist who prepared the information to be reported and the official who reviewed it:	Prepared by: Tseltmegkhishig N., Lawyer, Board Secretariat Reviewed by: Munkhtselmeg N., General Counsel and Corporate Secretary
1. Consent for Share Repurchase Program	
The Board of Directors of XacBank JSC has approved a Share Repurchase Program with a duration of 12 months by its Resolution No. R-2026-28 dated 01 May 2026 to enhance share liquidity, and the Bank of Mongolia granted the relevant consent on 22 July 2026.	
Signature and date of the person who prepared the information:	

Name: Tselmegkhishig N.

Position: Lawyer, Board Secretariat

Signature:



Reviewed by:

Munkhtselmeg N.

Position:

General Counsel and Corporate Secretary

Signature:



Date:

23 July 2026